



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 15 өдөр

Дугаар А/86

Хэрлэн сум

Эд хөрөнгө худалдах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 63 дугаар тогтоол, 2022 оны 11 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн өмчит 2 байгууллагын 69 351 833 төгрөгийн балансын үнэтэй, 45 939 543 төгрөг 85 мөнгөний хуримтлагдсан элэгдэлтэй, 23 412 289 төгрөг 15 мөнгөний үлдэх өртөгтэй худалдах 2 ширхэг тээврийн хэрэгслийг хавсралтаар баталсугай.

2.Худалдах эд хөрөнгийн нээлттэй дуудлагын худалдааг зохион байгуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн  
ахлагч:

Г.Лхагвахатан

Орон нутгийн өмчийн газрын  
дарга

Хөтлөгч:

С.Сосорбарам

Орон нутгийн өмчийн газрын  
мэргэжилтэн

Тэмдэглэл хөтлөгч:

Л.Отгончимэг

Орон нутгийн өмчийн газрын  
хуулийн зөвлөх

3.Худалдах эд хөрөнгийн нээлттэй дуудлагын худалдааг 2022 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 11:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын 106 тоот өрөөнд зохион байгуулсугай.

4.Эд хөрөнгийг худалдах ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахыг Орон нутгийн өмчийн газрын дарга (Г.Лхагвахатан)-д даалгасугай.

5.Аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/585 дугаар захирамжийн 2, 3, 4 дүгээр заалтуудыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231010273

Аймгийн Засаг даргын 2022 оны  
 02 дүгээр сарын 15 өдрийн 02/26...  
 дугаар захирамжийн хавсралт



ХУДАЛДАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Байгууллагын нэр	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн огноо	Ашиглалтад орсон огноо	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Сэргээн босгосон зардал	Худалдах үнийн санал		
									байгууллагын санал	ОНӨГ-ын санал	Хурлын шийдвэр
1	Баян-Адарга сумын ЭМТөв	УАЗ Хантер 79-27 ХЭҮ	2016	2017.01.13	29,351,833.00	21,606,210.55	7,745,622.45	10,650,000.00	7,745,622.45	7,750,000.00	7,750,000.00
2	Мөрөн сумын ЗДТГазар	Прадо-120 61-99 ХЭҮ	2004	2015.04.10	40,000,000.00	24,333,333.30	15,666,666.70	9,028,000.00	15,700,000.00	15,700,000.00	15,700,000.00
Нийт дүн					69,351,833.00	45,939,543.85	23,412,289.15	19,678,000.00	23,445,622.45	23,450,000.00	23,450,000.00